



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТАНИЛЦУУЛГА

# 2022

Улаанбаатар хот

ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ийн Статистикийн хэлтсийн  
дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Т.Хишигбаяр

ЧД-ийн Статистикийн хэлтсийн  
мэргэжилтэн



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС  
МОНГОЛ- УЛС, УЛААНБААТАР ХОТ  
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ III БАЙР, 401 тоот  
Утас: 70113013  
70130767  
70110767  
11-310767  
51-261125

Цахим хуудас: [www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

[www.chingeltei.gov.mn](http://www.chingeltei.gov.mn)

И-мэйл: [chingeltei@nso.mn](mailto:chingeltei@nso.mn)

## АГУУЛГА

БҮЛЭГ 1. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	4
1.1 Нийгмийн хамгааллын тухай ойлголт .....	4
1.2 Үндсэн ойлголт, тодорхойлолт .....	4
БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
2.1 Нийгмийн даатгалын тухай ойлголт .....	5
2.2 Нийгмийн даатгалд хамрагдагчид .....	7
2.3 Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын өнөөгийн байдал .....	8
БҮЛЭГ 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	
3.1 Нийгмийн халамжийн тухай ойлголт .....	11
3.2 Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага.....	12

## 1. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1.1 **Нийгмийн хамгааллын тухай ойлголт:** Хүмүүс өөрсдөөс үл хамаарах шалтгаанаар тухайлбал өвдөх, нас барах, хөдөлмөр эрхлэх боломжгүй болох, ажилгүй болох зэргээр эрсдэлд өртөх нь цөөнгүй байдаг. Нийгмийн хамгаалал хариуцсан төрийн байгууллагууд нь иргэд өндөр наслах, эмнэлгээр эмчлүүлэх, өвдөх, хөгжлийн бэрхшээлтэй болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн туслалцааг авах, түүнийг дуусгавар болгохтой холбогдон үүсэж байгаа харилцааг нийгмийн хамгааллын эрх зүйн дагуу зохицуулж байдаг.

**Нийгмийн хамгаалал:** Азийн хөгжлийн банкны тодорхойлсноор “Хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, хүмүүст тохиолдох эрсдэлийг бууруулах, аюул, осол тохиолдох болон ажил, орлогоо алдах зэрэг тохиолдолд өөрсдийгөө хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх замаар ядуурал, ядууралд өртөмтгий байдлыг бууруулах бодлого, хөтөлбөрүүдийн багц” юм.

Нийгмийн хамгаалал нь дараах 5 төрлөөс бүрддэг. Үүнд:

- ✓ Ажил эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай ажиллагаа, ажиллагчдыг хамгаалахад чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн бодлого, хөтөлбөрүүд
- ✓ Ажилгүйдэлтэй холбогдон үүсэх эрсдэлийг багасгах, өвдөх, хөгжлийн бэрхшээлтэй болох, гэмтэх, өндөр настанд чиглэсэн нийгмийн даатгалын хөтөлбөр
- ✓ Ганц бие эхчүүд, орон гэргүй юм уу биеийн, оюун санааны бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулан хамгийн эмзэг бүлгийн хүмүүст зориулсан нийгмийн халамж, тусламжийн үйлчилгээ
- ✓ Бичил зээл, хөдөө аж ахуйн даатгал, байгалийн гамшгийг удирдахад нийгмийн сан, хөтөлбөрүүдийг оролцуулан олон нийтийн түвшин дэх эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн бичил болон тухайн чиглэлд тулгуурласан хөтөлбөр/төлөвлөгөө
- ✓ Хүүхдийн эрүүл энх, ая таатай, бүтээлч хөгжлийг хангах хүүхэд хамгааллын хөтөлбөр, үйлчилгээ

## 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 2.1 Нийгмийн даатгалын тухай ойлголт, тодорхойлолт

**Даатгал** нь “эрсдлийг хаах” гэсэн утгатай бөгөөд нийгмийн даатгал нь Монгол Улсын төрийн даатгал хэлбэрээр оршдог. Нийгмийн даатгал нь нийгэм, эдийн засгийн өргөн хүрээтэй ойлголт бөгөөд иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх, агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ болно.


**Нийгмийн даатгал** нь нэг талаас аж ахуйн нэгж, байгууллага ажилтныхаа нийгмийн хамгааллыг хангах нөхцөл болдог, нөгөө талаас даатгуулагч иргэний амьдралынхаа бүхий л үеийн туршид тухайлбал, хөдөлмөрлөх явцдаа болон өвдөх, жирэмслэх, хүүхэд төрүүлэх, осолд орох, ажилгүй болох, өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдолд орлогогүй буюу орлого нь буурсан нөхцөлд тухайн хүний нийгмийн асуудлыг нь баталгаатайгаар хангадаг. Өөрөөр хэлбэл, аливаа даатгал нь эрсдэлийг зөөлрүүлэх, бууруулах, хохирлыг нөхөх агуулгыг илэрхийлж байдаг ба хүний амьдралд дараах эрсдэлүүд тохиолддог. Үүнд:

- ✓ Өндөр наслах
- ✓ Хөдөлмөрийн чадвараа алдах
- ✓ Ажилгүй болох
- ✓ Өвчлөх
- ✓ Тэжээгч нь нас барахад түүний асрамжид байгаа гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд орлогогүй болох
- ✓ Үйлдвэрлэлийн осолд өртөх
- ✓ Эдийн засгийн
- ✓ Байгалийн

Улс төрийн хүчин зүйлийн нөлөөллөөс болж иргэдийн орлогын чадвар буурах сөрөг үр дагавар гарах зэрэг урьдчилан таах боломжгүй нийгмийн шинжтэй амьдралын эрсдэлүүд байдаг.

## 2.2 Нийгмийн даатгалд хамрагдагчид

## ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛ, төрлөөр



**Тэтгэвэр** гэдэг нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Тэтгэмж** гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Үйлдвэрлэлийн осол** гэж Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг үйлдвэрлэлийн осол гэнэ.

**Мэргэжлээс шалтгаалсан өвчин** гэж Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг “мэргэжлээс шалтгаалсан өвчин” гэнэ.

**Ажилгүйдлийн тэтгэмж** нь даатгуулагчид учирсан эрсдэлийг бууруулах, хуваалцах, ажилгүй болсон даатгуулагчийг дараагийн ажилд орж орлоготой болох хүртэлх хуулиар тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын сангаас амьдралын баталгааны эх үүсвэр болгон олгож буй мөнгөн хөрөнгө юм.

Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоонд хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий иргэдийг хамруулдаг.

## ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ИНФО



## НИЙГМИЙН ДААТГАЛ, 2022 оны байдлаар

2022 оны  
 1-9 сарын  
 байдлаар

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг



\* ҮОМШӨ - үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин


## → НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

Албан журмаар даатгуулагчид

Сайн дураар даатгуулагчид



## → ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД





## 2.3 ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2022 оны эхний 12 сард дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээнд 4.6 мянган байгууллагын 118.3 мянган иргэн, сайн дурын 8.0 мянган иргэн бүгд 126.4 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.


Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 91.6 мянга (72.5%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 26.6 мянга (21.1%) нь төсөвт байгууллагын, 8.0 мянга буюу (6.4%) нь сайн дурын даатгуулагчид байна.

### ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2019 I-XII	2020 I-XII	2021 I-XII	2022 I-XII
Нийгмийн даатгалын сангийн орлого	242.3	267.6	292.1	464.7
Өмнөх онтой харьцуулсан өсөлт, бууралт, хувиар	2.1%	10.4%	9.2%	59.1%

Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 онд өмнөх оны мөн үеэсээ 2.1 хувиар, 2020 онд өмнөх оны мөн үеэсээ 10.4 хувиар, 2021 онд өмнөх оны мөн үеэсээ 9.2 хувиар, 2022 онд өмнөх оны мөн үеэсээ 59.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 3. ДААТГАЛЫН САНГИЙН САНГИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг, өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувиар



2022 оны эхний 12 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 8.1 хувиар давуулан биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 464.7 тэрбум төгрөг хуримтлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 172.6 тэрбум төгрөг буюу 59.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.



ЗУРАГ 4. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГОД САНГУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, хувиар



Даатгалын санд хуримтлуулсан нийт жилийн орлогын 83.4 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 8.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 1.4 хувь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.


ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДАЛ, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2019 I-XII	2020 I-XII	2021 I-XII	2022 I-XII
Нийгмийн даатгалын сангийн зардал	116.6	132.2	137.7	461.6
Өмнөх онтой харьцуулсан өсөлт, бууралт, хувиар	4.5%	13.4%	4.2%	35.2%

\*Эх үүсвэр: Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын мэдээллээс

Нийгмийн даатгалын сангийн орлого 2019 онд өмнөх оны мөн үеэсээ 4.5 хувиар, 2020 онд өмнөх оны мөн үеэсээ 13.4 хувиар, 2021 онд өмнөх оны мөн үеэсээ 4.2 хувиар, 2022 онд өмнөх оны мөн үеэсээ 35.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Нийгмийн даатгалын сангийн зардал 2022 оны эхний 12 сард 461.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 323.9 тэрбум төгрөг буюу 3.4 дахин өссөн үзүүлэлттэй гарсан байна.

ЗУРАГ 6. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГАД САНГУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Нийт зардлын 88.3 хувийг тэтгэврийн, 8.6 хувийг тэтгэмжийн, 0.6 хувийг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, 2.4 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал тус тус эзэлж байна.



## 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

### 3.1 Нийгмийн халамжийн тухай ойлголт

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Аль ч улс орны хөгжлийн бодлогод чухал үүрэг гүйцэтгэдэг.

Нийгмийн халамжаар дамжуулан нөөцийг ядуучуудад дахин хуваарилснаар туйлын ядуурлыг бууруулж, өрх гэр бүлд өөрийнхөө ирээдүйд хөрөнгө оруулах, эрсдэлийг даван туулах боломж олгодог бол Засгийн газарт макро эдийн засгийн түвшинд, худалдаа, хөдөлмөр эрхлэлт болон бусад олон салбарт бодлогын зөв шийдвэр гаргахад тусалдаг.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зааснаар нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь:

- ✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр
- ✓ Нийгмийн халамжийн тэтгэмж
- ✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ
- ✓ Нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн дөрвөн хүрээг хамарч байна.

Түүнчлэн холбогдох хуулийн дагуу алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал, ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг тус тус олгож байна.

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6, 7 дугаар зүйлд заасны дагуу халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан бөгөөд улс, орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө, сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, олон улсын байгууллага, гадаад улсаас өгсөн хандив, тусламж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, бусад эх үүсвэр гэсэн эх үүсвэрүүдээс бүрддэг.

Нийгмийн халамжийн статистикийн мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын захиргааны бүртгэлийн мэдээлэлд үндэслэн, нийгмийн халамжийн сангийн орлого, түүний эх үүсвэр, үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн хүн ам, зарцуулсан хөрөнгийн талаарх мэдээллийг танилцуулж байна.

### 3.2 Чингэлтэй дүүргийн нийгмийн халамжийн сангийн орлого, зарлага

Нийгмийн халамжийн сангийн орлого 2022 оны эхний 12 сард 16.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.7 (70.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Халамжийн сангийн орлогын 47.2 хувийг халамжийн тэтгэвэр, 17.2 хувийг халамжийн тэтгэмж, 14.0 хувийг амьжиргаа дэмжих мөнгөн тусламж, 9.1 хувийг ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, 7.3 хувийг хүнс тэжээл тус тус бүрдүүлж байна.

#### ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг

Сангийн төрөл	2022 I-XII	Эзлэх хувь
<b>Нийгмийн халамжийн сангийн орлого /А+Б/</b>	<b>16 300.9</b>	<b>100.0</b>
<b>А. Улсын төсөв</b>	<b>16 056.7</b>	<b>98.5</b>
Халамжийн тэтгэвэр	7 690.0	47.2
Халамжийн тэтгэмж	2 804.5	17.2
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	2 287.2	14.0
ХБИ-д үзүүлэх тусламж	607.9	3.7
Хүнс тэжээл /Улсын төсөв/	1 191.2	7.3
Ахмад настануудад үзүүлэх хөнгөлөлт	1 475.9	9.1
АДЗУрамшууллын санхүүжилт		
Банкны шимтгэлийн санхүүжилт		
<b>Б. Орон нутгийн төсөв</b>	<b>244.2</b>	<b>1.5</b>
Халамжийн сангийн санхүүжилт	56.4	0.3
ОНОТХҮйлчилгээний санхүүжилтийн орлого	187.8	1.2

#### ЗУРАГ 7. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сая төгрөг



Нийгмийн халамжийн сангийн зарлага 2022 оны эхний 12 сард 16.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.9 (75.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн сан нь 2571 хүнд халамжийн тэтгэвэр, 3247 хүнд халамжийн тэтгэмж, 30116 хүнд амьжиргаа дэмжих мөнгөн тусламжийг тус тус олгосон байна. Халамжийн сангийн зарлагад халамжийн тэтгэвэр 7.7 (47.9%) тэрбум төгрөг, халамжийн тэтгэмж 2.8 (17.5%) тэрбум төгрөг, амьжиргаа дэмжих мөнгөн тусламж 5.6 (34.6%) тэрбум төгрөгийг тус

тус эзэлж байна.ХҮСНЭГТ 1 . НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ,  
сая.төг

Халамжийн төрөл	Хүний тоо	Зардал
<b>ХАЛАМЖИЙН ЗАРЛАГА /А+Б+В/</b>	<b>35934</b>	<b>16 056.7</b>
<b>А. Халамжийн тэтгэвэр</b>	<b>2571</b>	<b>7 690.0</b>
Ахмад настны тэтгэвэр	368	1 073.4
Хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан ХБИ	484	1 761.4
Хөдөлмөрийн чадвараа 70-с дээш алдсан ХБИ	968	2 495.3
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	4	9.1
Өрх толгойлсон эх/эцэг /-ийн халамжийн тэтгэвэр	3	6.2
Тэжээгч нас барсан 18 хүртлэх насны хүүхдийн тэтгэвэр	744	2 344.5
<b>Б. Халамжийн тэтгэмж</b>	<b>3247</b>	<b>2 804.5</b>
Ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	1683	1 209.7
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	646	786.7
Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	808	684.2
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	92	104.2
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	16	17.7
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	2	2.0
<b>В. Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж</b>	<b>30116</b>	<b>5 562.2</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	578	1 840.1
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	1815	447.1
ХБИ-д үзүүлэх тусламж / 7000	3350	607.9
Хүнс тэжээл / 8301 /Улсын төсөв/	8563	1 191.2
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт / 5000	15810	1 475.9

**Ойлголт, тодорхойлолт**

**Нийгмийн даатгал:** Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

**Нийгмийн даатгалын сан:** Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Даатгуулагч:** Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

**Тэтгэвэр:** Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

**Тэтгэмж:** Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Хайх ...



**СТАТИСТИКИЙН** мэдээллээ аваарай

**Data lab**

тооллого судалгааны  
микро мэдээллийн сан



**Social network**



/StatisticMGL

**Лавлах утас**



**1900-1212**

**Цахим шуудан**



**information@nso.mn**